


МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДВИЙН ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ, УРАНЗОХИОЛЫН БОЛОВСРОЛ, НОМЫН САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Р.ӨЛЗИЙХҮҮ

1. Монгол хэлний хичээлийн шалгалтыг эх, хэл зүй, найруулга, монгол бичиг, уран зохиол гэсэн агуулгын хүрээнд 2 хувилбар, 40 асуулттайгаар боловсруулсан байна. “А” хувилбарт 2778, “В” хувилбарт 2399 сурагч шалгагдсан байна.

“В” хувилбарын дүгнэлт




Шалгалтын төстийн хэвийн тархалтын графиктай анхны онооны тархалтын муруйг харьцуулж харахад тархалтын орой нь дундаж гүйцэтгэлийн талруу /38-50 хувь/ шилжилттэй гарсан байгаа нь сэдвийн хувьд боломжийн байна.

SCALE 1		DISTRIBUTION				STATISTICS		DECILES		STANINES	
40.00	Maximum obtainable score	16.97	Mean score	3.26	Skewness 2 (p of larger z = .001)	22.95	8	27.48			
32.00	Highest obtained score	4.45	Standard deviation	.06	Kurtosis 2 (p of smaller z = .523)	20.60	8	25.31			
19.82	Upper quartile (75th pct)	19.82	Variance	-.001	Gamma-1 (indicates distribution is peaked like a normal curve)	19.82	6	22.74			
16.82	Median (50th percent ile)	2399	Number of records	.640	Reliability (Cronbach's alpha)	11.65	3	13.54			
4.00	Lower quartile (25th pct)	2399	Modal frequency	.953	Determination coefficient	13.15	2	11.59			
4.00	Minimum possible score	1	Number of modes	.091	Standard error of the mean	11.47	1	9.45			
29.00	Range (highest - lowest + 1)										
2.90	Interquartile range										
2.95	Semi-Interquartile range										
33.08	Mean percent of highest score	40714.00	Sum of scores			17.33		16.74			
32.43	Mean percent of maximum possible	738630.00	Sum of squares			16.79		16.74			

SCORE	COUNT	CUMULATIVE COUNT	PERCENT	CUMULATIVE PERCENT	PERCENT POSSIBLE	PERCENT HIGHEST OBTAINED	RANK	PERCENTILE RANK	Z	T SCORE	SCORE	GRADE	GRADE COUNT
32	1	1	0.04	100.0	80.0	100.0	1.0	100.0	1.27	83.2	32		
31	0	1	0.00	100.0	80.0	99.9	1.0	100.0	1.15	82.0	31		
30	8	9	0.34	100.0	77.5	99.8	1.0	99.9	1.04	79.5	30		
29	9	18	0.38	100.0	70.0	99.8	1.0	99.8	0.92	74.7	29		
28	11	29	0.46	99.9	62.5	99.8	1.0	99.7	0.81	72.5	28		
27	17	46	0.71	99.8	55.0	99.7	1.0	99.6	0.70	68.0	27		
26	40	86	1.67	99.7	47.5	99.6	1.0	99.5	0.58	61.3	26		
25	53	139	2.21	99.6	40.0	99.5	1.0	99.4	0.47	54.7	25		
24	56	195	2.38	99.5	32.5	99.4	1.0	99.3	0.35	48.0	24		
23	77	272	3.21	99.4	25.0	99.3	1.0	99.2	0.24	41.3	23		
22	87	359	3.63	99.3	17.5	99.2	1.0	99.1	0.13	34.6	22		
21	134	493	5.58	99.2	10.0	99.1	1.0	99.0	0.02	28.0	21		
20	157	650	6.54	99.1	2.5	99.0	1.0	98.9	0.01	21.3	20		
19	191	841	7.97	99.0	0.0	98.9	1.0	98.8	0.00	14.6	19		
18	198	1039	8.26	98.9	0.0	98.8	1.0	98.7	0.00	7.9	18		
17	235	1274	9.80	98.8	0.0	98.7	1.0	98.6	0.00	1.2	17		
16	226	1500	9.43	98.7	0.0	98.6	1.0	98.5	0.00	0.0	16		
15	212	1712	8.84	98.6	0.0	98.5	1.0	98.4	0.00	0.0	15		
14	150	1862	6.27	98.5	0.0	98.4	1.0	98.3	0.00	0.0	14		
13	165	2027	6.89	98.4	0.0	98.3	1.0	98.2	0.00	0.0	13		
12	130	2157	5.44	98.3	0.0	98.2	1.0	98.1	0.00	0.0	12		
11	73	2230	3.07	98.2	0.0	98.1	1.0	98.0	0.00	0.0	11		
10	71	2301	2.96	98.1	0.0	98.0	1.0	97.9	0.00	0.0	10		
9	42	2343	1.76	98.0	0.0	97.9	1.0	97.8	0.00	0.0	9		
8	24	2367	1.00	97.9	0.0	97.8	1.0	97.7	0.00	0.0	8		
7	15	2382	0.63	97.8	0.0	97.7	1.0	97.6	0.00	0.0	7		
6	9	2391	0.38	97.7	0.0	97.6	1.0	97.5	0.00	0.0	6		
5	3	2394	0.13	97.6	0.0	97.5	1.0	97.4	0.00	0.0	5		

Энэ хүснэгтээс харахад дундаж оноо нь 16.97 байна. Авбал зохих 40 онооноос хамгийн өндөр 32 оноог 1 сурагч авсан бөгөөд хэмжээст оноо (T score) нь 83.7 байна.

Боловсролын Үнэлгээний төвөөс боловсруулсан сэдвийн даалгаврыг сурагчдын хариултаас нь дүгнэж үзвэл 40 даалгаврын 8 даалгавар нь маш сайн, 7 нь сайн, 17 нь дундаж, тус бүр 3 муу буюу маш муу даалгавартай байна. Үүнийг графикаар үзүүлэхэд:



Сэдвийн бүтцийг шинжлэн үзвэл сонгох даалгавар 36 байгаагаас монгол хэл 25, үндэсний бичиг 7, уран зохиолын 4, харгалзуулах даалгавар 4 байгаагаас монгол хэл 2, уран зохиол, үндэсний бичгийн даалгавар нэг нэг асуултайгаар боловсруулсан байна. Агуулга тус бүрийн эзлэх хувийг графикаар харуулбал:



Даалгаврын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулъя:


Даалгавар	1	2	3	4	5	6	7	8	9	10
Зөв хийсэн сурагчдын тоо	2193	2208	1643	1860	1526	703	1586	370	647	456
Нийт шалгуулагч	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399
Гүйцэтгэлийн хувь	91.4	92.0	68.5	77.5	63.6	29.3	66.1	15.4	27.0	19.0
Даалгавар	11	12	13	14	15	16	17	18	19	20
Зөв хийсэн сурагчдын тоо	541	614	1528	1067	915	1246	1539	416	691	204
Нийт шалгуулагч	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399
Гүйцэтгэлийн хувь	22.6	25.6	63.7	44.5	38.1	51.9	64.2	17.3	28.8	8.5
Даалгавар	21	22	23	24	25	26	27	28	29	30
Зөв хийсэн сурагчдын тоо	583	2012	380	1028	1969	572	274	819	1269	1602
Нийт шалгуулагч	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399
Гүйцэтгэлийн хувь	24.3	83.9	15.8	42.9	82.1	23.8	11.4	34.1	52.9	66.8
Даалгавар	31	32	33	34	35	36	37	38	39	40
Зөв хийсэн сурагчдын тоо	599	1054	746	1151	540	1008	1743	336	716	360
Нийт шалгуулагч	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399	2399
Гүйцэтгэлийн хувь	25.0	43.9	31.1	48.0	22.5	42.0	72.7	14.0	29.8	15.0

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувиас харахад үндэсний бичгээр унших, эхийг уншаад ойлгох чадвар болон харгалзуулах даалгавруудын гүйцэтгэл сайн байна.

2. Монгол хэл, уран зохиол, үндэсний бичгийн асуулт тус бүрийг дүгнэж үзэхэд:


I. Монгол хэл

Монгол хэлний даалгаварт эхтэй холбоотой 7, өгүүлбэр 7, үг 6 (харгалзуулах 1), бүтээвэр 3 (харгалзуулах 1), зөв бичгийн дүрэмтэй холбоотой даалгавар 4 тус тус оногджээ.



- “Эх” сэдвийн хүрээн дэх мэдлэг, чадварыг үнэлсэн даалгаврын ерөнхий дундаж үнэлгээ 70%-тай байгаа нь хангалттай үзүүлэлт гэж үзэж байна. Үүн дотроо эхийг уншаад ойлгох чадварыг илрүүлэх 1. 2-р даалгавар 90-ээс дээш хувьтай байгаа нь эхийг уншиж ойлгох чадвар өндөр байгааг харуулж байна. Харин эхийн утга, бүтцийг тодорхойлох чадвар (3.4.5.7-р асуулт) дунд зэрэг, хэв маягийг тодорхойлох (6-р даалгавар) маш муу гүйцэтгэлтэй байгаа тул “Эхийн хэв маяг”, түүнийг тодорхойлох дасгал, дадлага түлхүү хийхийн чухлыг анхаарууштай.
- “Өгүүлбэр” сэдвийн хүрээнд авсан асуултын нийлбэр онооны дундаж 31%-тай байгаа нь анхаарал татаж байгаа юм. Үүнийг задалж үзвэл өгүүлбэрийн бүтцийн асуултуудад (8, 9, 10, 11-р асуулт) сурагчид маш их оноо алджээ. Тиймээс өгүүлбэрийн бүтцийг дахин заан таниулах, учир зүй логик холбоог олж тогтоох, задлан шинжлэх дасгал даалгаврыг ахиухан хийх хэрэгтэй байна. Харин өгүүлбэрийн хувиргал, хэрэглээний асуултуудад (12, 13, 14-р асуулт) дундаж үнэлэгээтэй байна. Цаашид өгүүлбэрийн утгыг хувиргаж соёл, бүтцийг хувиргаж хэрэглээ болох учир утга бүтэц, хэрэглээг салгаж болохгүй цогц байдлаар заан эзэмшүүлэхэд анхаараарай.
- Үг бүлгийн хүрээн дэх асуулт даалгаврын гүйцэтгэлийн ерөнхий дундаж 32%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнээс үгийн утгатай холбоотой асуулт хамгийн өндөр (15, 17-р асуулт), үгийн бүтэцтэй холбоотой асуултад (18, 2.1, 2.3 асуулт) бид анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Үгийн бүтэц нь зөв бичихийн, өгүүлбэр бүтэхийн эх үндэс болно, тиймээс орхигдуулж болохгүйг анхаарах хэрэгтэй.
- Бүтээвэр бүлгийн асуултуудын дундаж 54%-тай байна.
- Зөв бичгийн дүрмийн асуулт даалгаврын дундаж үнэлгээ 32%-тай байгаа нь сул үнэлэгдсэнийг харуулж байна. Тиймээс үгэнд нөхцөлийг зөв залгах, хаалт хашилтыг зөв хэрэглэх талаар “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” УБ.,2017 номоо ашиглан, сурагчид өөрийн зохион найруулж бичсэн эхийн үг бүрийг алдаагүй зөв бичиж сурах аргад сургах, зөв бичих дадлыг суулгах хэрэгтэй.

Үнэлгээний дунджийн харьцуулалтыг графикаар үзүүлбэл:



Эндээс үзэхэд монгол хэлний боловсролыг эх дээр суурилан заах арга технологи амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч хэлнийхээ дотоод дүрэм журам, зүй тогтлыг хэт орхигдуулж байна уу даа гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Тиймээс эхэд суурилан хэл зүйгээ зохистой харьцаагаар зааж байх нь чухал санагдана.

II. Уран зохиол

Уран зохиолын даалгаварт харгалзуулах даалгавар 4, сонгох даалгавар 1 байгаа нь нийт даалгаврын 12.5%-г эзэлж байна.

Даалгаврын гүйцэтгэлд дүгнэлт хийхэд:

- Орчин үеийн зохиолоос зохиолын нэрийг ишлэлтэй нь харгалзуулах даалгаврын ерөнхий дундаж үнэлгээ 15%, зохиолын нэрсийг төрөл зүйлтэй нь тохируулан харгалзуулах даалгаврын ерөнхий дундаж үнэлгээ 23.8 % - тай байгаа нь хангалтгүй үзүүлэлт байна. Харин яруу найргийн ойлголт 68%-тай байгаа нь хангалттай үзүүлэлт гэж үзэж байна.
- Эртний уран зохиолын даалгаврын гүйцэтгэл 43%-тай байна. Иймээс:
 1. Уран зохиолын төрөл зүйл, орчин үеийн уран зохиол, эртний уран зохиол, монгол ардын аман зохиол талаар нэлээд нухацтай заах
 2. Сурагчдыг уран зохиолд дуртай, зохиолчдын уран бүтээлүүдийг харьцуулан уншдаг, шинжилгээ хийдэг, туурвил зүйн онцлогт нь дүгнэлт гаргадаг, зохиолчийн үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулан, судлаач байдлаар идэвхтэй уншлага хийдэг болгоход бидний зорилго оршиж байгаа билээ. Иймд энэ талын асуулт даалгаврыг гүйцэтгүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

III. Үндэсний бичиг

Нийт даалгаврын 20%-ийг үндэсний бичгийн даалгавар эзэлж байна. Сурагчид үндэсний бичгээр эхийг уншаад зөв хөрвүүлснийг олох даалгаврыг сайн гүйцэтгэсэн байна. Гэвч цаашид үндэсний бичгээр дараах зүйлүүдийг анхаарах шаардлагатай байна.

Үүнд:

- Дуудлага ижил бичлэг өөр үгсийг нүдлүүлэх, зөв галиглуулахад онцгойлон анхаарах
- Үндэсний бичгийн зөв бичих дүрэмд тулгуурласан дасгал ажлуудыг сайн хийлгүүлэх
- Үндэсний бичгээр бичсэн эхүүдийг шударга, зөв уншуулахад анхаарах

Ерөнхий дүгнэлт:

1. Сурагчдаар эх зохиолуудыг уншуулах, харилцан ярилцах, сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах
2. Монгол хэлний хичээлээр сурагчдын эзэмшсэн хэлний зүйн мэдлэг чадвар, уншиж ойлгох, бичиж найруулах, ярих-сонсох чадварыг хөгжүүлэхэд эх хэлний сургалтыг чиглүүлэх
3. Шинэчилсэн цөм хөтөлбөрт дүрслэх ур маягийг таньж, тодорхойлохоос илүү тайлбарлах чадварыг хөгжүүлэхийг зорьж байгаа билээ. Тиймээс сурагчид утга зохиолын онолын мэдлэгээ хэрэглээ болгох
4. Сурагчдаас авсан шалгалтын материалыг багш өөрөө хийж дүгнэлт хийн ажиллаж байх